



НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Үүрэг хэрэгжүүлэх тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 12 дугаар сарын А/224 дүгээр тушаал, 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/511 тоот үүрэг чиглэл өгөх тухай албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын системийн аюулгүй ажиллагааны журам"-д заасны дагуу нийт шийдвэр гүйцэтгэгч нар гүйцэтгэлийн ажиллагаатай болон түдгэлзүүлсэн баримт бичгийг 2014 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн дотор, баяжилтыг 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор цахим бүртгэлийн системд бүрэн хийж дуусгасугай.

2.Шийдвэр гүйцэтгэгч нэг бүрийн бүртгэлийн системд хяналт тавихыг дүүргүүдийн ахлах гүйцэтгэгч нарт, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдийн бүртгэлд хяналт тавихыг дэд дарга, дэд хурандаа Ч.Оюунцэцэг, Баянзүрх, Баянгол, Хан-Уул дүүргүүдийн бүртгэлд хяналт тавьж ажиллахыг дэд дарга, хошууч Ж.Нандинтуул, техникийн гэмтэл, доголдол тасралгүй ажиллагааг хангаж, заавар зөвлөгөө өгч ажиллахыг программист, дэслэгч Б.Гүнчинсүрэн нарт тус тус даалгасугай.


3.Гүйцэтгэх баримт бичгийн мэдээллийг цахим бүртгэлд бүрэн оруулж нэгтгэн 2013 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн өглөөний шуурхай хуралд танилцуулахыг дэд дарга, дэд хурандаа Ч.Оюунцэцэг, дэд дарга, хошууч Ж.Нандинтуул нарт үүрэг болгосугай.

4. Дурдсан хугацаанд бүртгэлийг хийж дуусгавар болгоогүй албан хаагч, хяналт тавьсан албан тушаалтнуудад хуульд заасны дагуу хариуцлага тооцохыг анхааруулсугай..

5. Дээрх хугацаанд өдөр бүр уртасгасан цагаар ажиллахыг ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч программист, дэслэгч Б.Гүнчинсүрэн нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Э.БАТБАЯР



2014 tushaal

117550000053